



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/95

Амардалай

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 21 дүгээр зүйлийн 21.4.3, 27 дугаар зүйлийн 27.1, 33 дугаар зүйлийн 33.1.1, Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтууд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 40 тоот тогтоолоор баталсан "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын суурьшлын бүсээс гаднах нутаг дэвсгэрт хамрагдаж байгаа Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай 660349 м.кв (66 га) талбай бүхий 6.6 км урттай авто замын зурвас газрыг Зам, тээврийн яам (5919487)-д 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ